



ИНД-102

Иргэний Нисэхийн Багц Дүрэм

**Хүнгүй агаарын хөлгөөр
үйл ажиллагаа эрхлэгч - Гэрчилгээжүүлэлт**

Иргэний нисэхийн ерөнхий газар

ДҮРМИЙН ТАЙЛБАР

ИНД-102-ийн зорилго нь хүнгүй агаарын хөлгийн гэрчилгээжүүлэлт болон ИНД-101-ээс гадуурх үйл ажиллагааны шаардлагыг тогтооход оршино.

Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-102-ийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-102, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн энэхүү багц Дүрмийг боловсруулсан.

Өөрчлөлтийн түүх

Анхны боловсруулалт

Хүчинтэй огноо

2018 оны ... сарын ...

Тэмдэглэл: ИНД-102-ийн анхны боловсруулалтыг англи болон монгол хэл дээр, NZ Part 102 А.1-д үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

102.1.	Зорилго	5
102.3.	Хамрах хүрээ	5
102.5.	Тодорхойлолт	5
102.7.	Гэрчилгээжих шаардлага	5
102.9.	Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ эзэмших хүсэлт ..	5
102.11.	Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн Ерөнхий заавар.....	6
102.13.	Гэрчилгээ олгох	7
102.15.	Үйл ажиллагааны тодорхойлолт	7
102.17.	Гэрчилгээ эзэмшигчийн эрх.....	8
102.19.	Гэрчилгээний хугацаа	8
102.21.	Хүнгүй агаарын хөлгийн үйл ажиллагааны нөхцөл.....	8
102.23.	Ерөнхий зааварт өөрчлөлт оруулах.....	8
102.25.	Гэрчилгээ сунгах.....	9

102.1. Зорилго

Энэ дүрмийн зорилго нь, Дарга тухайн этгээдийг дараах шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлсны дараа, хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ олгох эсэхийг тогтооход оршино:

- (1) тухайн санал болгосон хүнгүй агаарын хөлгийн үйл ажиллагааг гүйцэтгэх аюулгүй байдлын эрсдэлийн тохирох үнэлгээг хийсэн байх;
- (2) тухайн эрсдэлийг зохистой удирдах болон үйл ажиллагааг аюулгүй гүйцэтгэхийг бататгасан журам боловсруулсан байх.

102.3. Хамрах хүрээ

Энэ Дүрэм нь дараах этгээдэд хамаарна:

- (1) хүнгүй агаарын хөлгөөр ИНД-101-д зааснаас бусад үйл ажиллагаа эрхэлж байгаа;
- (2) хүнгүй агаарын хөлгөөр ИНД-101-ийн дагуу үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшихийг хүсэж байгаа.

102.5. Тодорхойлолт

Ерөнхий заавар гэж, тухайн агуулгыг өөрөөр шаардаагүй бол, 102.11-ээр шаардсан Ерөнхий зааврыг ойлгоно.

102.7. Гэрчилгээжих шаардлага

Аливаа этгээд, хууль болон энэ Дүрмийн дагуу Даргын олгосон хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн хүчинтэй гэрчилгээний эрхийн хүрээ болон нөхцөлд зааснаас бусад тохиолдолд, хүнгүй агаарын хөлгөөр ИНД-101-д зааснаас бусад үйл ажиллагааг эрхлэхийг хориглоно.

102.9. Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ эзэмших хүсэлт

- (a) Аливаа этгээд, хүнгүй агаарын хөлгөөр ИНД-101-д зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэхийн өмнө хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах үүрэгтэй.
- (b) Хүнгүй агаарын хөлгөөр ИНД-101-ийн дагуу үйл ажиллагаа эрхэлж буй этгээд нь хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргаж болно.
- (c) Энэ зүйлийн (a), эсхүл (b)-д заасан этгээд нь дараах үүрэгтэй:
 - (1) САА 24102/01 маягтаар Даргад хүсэлт гаргах;
 - (2) хуулийн дагуу, дүрэмд заасан зохих хураамжийн төлбөрийг төлөх.
- (d) Хүсэлт нь дараах мэдээллийг багтаасан байх ёстой:

- (1) тухайн хүсэлт гаргагчийн нэр болон Монгол Улсад ажил үүрэг гүйцэтгэх хаяг;
- (2) 102.15-д шаардсан, үйл ажиллагааны тодорхойлолтын дэлгэрэнгүй;
- (3) 102.11-д шаардсан, хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар;
- (4) тухайн хүсэлттэй холбоотой Даргын шаардаж болох аливаа бусад мэдээлэл.

102.11. Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн Ерөнхий заавар

(a) Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц Ерөнхий зааврыг Даргад ирүүлэх үүрэгтэй.

(b) Тухайн Ерөнхий зааварт, зорьж буй үйл ажиллагааны мөн чанар, эрсдэл болон түвшинтэй холбоотой дараах журмыг тусгасан байх ёстой:

- (1) тухайн үйл ажиллагаанд үндсэн үүрэг хариуцлага хүлээх этгээдийг тодорхойлох;
- (2) тухайн гэрчилгээний дагуу эрхийг хэрэгжүүлэхэд хяналт тавих эрх бүхий, эсхүл хяналт тавих боломжтой аливаа этгээдийг тодорхойлох;
- (3) тухайн үйл ажиллагаанд ашиглах бодит байрлалын дэлгэрэнгүй;
- (4) дараах ажиллагааг багтаасан аюулын бүртгэл:
 - (i) тухайн санал болгосон үйл ажиллагааны улмаас хүмүүс, өмч хөрөнгө болон бусад агаарын хөлөгт учирч болох, мэдэгдэж байгаа болон болзошгүй аюулыг таньж тогтоох;
 - (ii) тухайн таньж тогтоосон аюул бүрийн хувьд, холбогдох эрсдэлийн үнэлгээг;
 - (iii) тухайн эрсдэлийг багасгах, эсхүл удирдахад авч хэрэгжүүлэх арга хэмжээний тодорхойлолтыг.
- (5) ИНЕГ-т мэдээллийг тайлагнах;
- (6) нисгэгч болон багийн бусад гишүүдийн мэргэшил, сургалт, эсхүл эрүүл мэндийн шаардлагыг багтаасан, ажилтнуудын үнэмлэхжүүлэлт, мэргэшил, сургалт болон ур чадварт тавих үйл ажиллагааны шаардлага;
- (7) тухайн агаарын хөлөгт ашигласан аливаа таньж тогтоох тогтолцоо (будгийн схем, онцлог таних дугаар, тэмдэглэгээ зэрэг)-г багтаасан, ашиглах гэж буй агаарын хөлгийн тоо болон тодорхойлолтын дэлгэрэнгүй;
- (8) тухайн агаарын хөлгийн нисгэгчийн ашигладаг удирдлагын системийн дэлгэрэнгүй;
- (9) агаарын хөлгийн техник үйлчилгээний журам болон нислэгт тэнцэх чадварын хадгалалтыг бататгах арга хэмжээ;
- (10) хүмүүс, эсхүл өмч хөрөнгө хүртэлх минимум зайг багтаасан нислэгийн үеийн журам;
- (11) ачаа тээвэрлэх, эсхүл эд зүйлсийг агаараас хаях журам, хэрэв эдгээр ажиллагааг хийхээр зорьж байгаа бол;

- (12) заавал хангасан байх нислэгт тэнцэх чадварын үндсэн, суурь стандарт;
- (13) тухайн Ерөнхий зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт хийх болон түгээх журам;
- (14) тухайн санал болгосон үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай бусад аливаа зөвшөөрөл.

(с) Энэ дүрмийн 102.11(b)(4)-д шаардсан аюулын бүртгэлд таньж тогтоогдсон эрсдэлийг бууруулах, эсхүл удирдах зорилгоор ИНД-ийн шаардлагыг Ерөнхий заавартаа ишлэлээр оруулж болно.

(d) Дарга энэ зүйлийн (b)-д заасан асуудлаас зөвхөн тухайн тодорхой нөхцөл байдалд тохирно гэж үзсэнийг Ерөнхий зааварт тусгахыг шаардаж болно.

(e) Тухайн Ерөнхий заавар нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц хэвээр байх ёстой.

102.13. Гэрчилгээ олгох

(a) Дарга, ИНД-ийн холбогдох Дүрмийн дагуу, 102.9-ийн хүрээнд хүсэлт гаргасан этгээдэд гэрчилгээ олгож болно.

(b) Дарга, энэ зүйлийн (a)-ийн дагуу гэрчилгээ олгохдоо:

- (1) хүнгүй агаарын хөлгийн системд тавих шаардлагыг тогтоож, тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулах хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн дагаж мөрдөх журмыг тогтоож болно;
- (2) шаардлагатай бол, Дарга нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд анхаарах шаардлагатай гэж үзсэн аливаа нэмэлт нөхцөлийг зааж болно;
- (3) Дарга тухайн ашиглах гэж буй агаарын хөлгийн маягийг судалсны дараа, хэрэв нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай гэж үзвэл, тухайн гэрчилгээний хүрээнд үйл ажиллагаа явуулах аливаа агаарын хөлгийн бүртгүүлэх шаардлагыг тогтоож, ИНД-47-ийн дагуу таних тэмдэглэгээ байрлуулж болно.

102.15. Үйл ажиллагааны тодорхойлолт

(a) Хэрэв Дарга 102.13-ын дагуу хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ олгох бол, тухайн гэрчилгээ нь энэ зүйлийн (b)-д заасан дэлгэрэнгүйг багтаасан Үйл ажиллагааны тодорхойлолтын хамт олгогдох ёстой.

(b) Тухайн үйл ажиллагааны тодорхойлолт нь дараах мэдээллийг багтаасан байх ёстой:

- (1) тухайн гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны үндсэн баазын бодит байрлалын дэлгэрэнгүй;
- (2) тухайн гэрчилгээ эзэмшигчийн Монгол Улсад үйлчилгээ үзүүлэх хаяг;
- (3) тухайн гэрчилгээ эзэмшигчийг үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрсөн бизнесийн нэрийн жагсаалт;
- (4) тухайн үйл ажиллагаа эрхлэгч гүйцэтгэхийг зөвшөөрсөн, дараах мэдээллийг багтаасан эрх болон үйл ажиллагаа:

- (i) ашиглахыг зөвшөөрсөн агаарын хөлөг бүрийн тоо, маяг болон үзүүлэлт, хэрэв хамааралтай бол серийн болон бүртгэлийн дугаар;
 - (ii) Даргын зөвшөөрсөн, үйл ажиллагаа явуулах газар зүйн бүсийн тодорхойлолт;
 - (iii) энэ Дүрмийн, эсхүл аливаа бусад Дүрмийн шаардлагаас чөлөөлсөн аливаа заалт;
- (5) Дарга, нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай гэж тогтоосон аливаа нэмэлт нөхцөл.

102.17. Гэрчилгээ эзэмшигчийн эрх

- (a) Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь, дагалдах Үйл ажиллагааны тодорхойлолтод заасан үйл ажиллагааг гүйцэтгэх эрхтэй.
- (b) Энэ дүрмийн 102.11-д шаардсан Ерөнхий зааварт өөрөөр заагаагүй бол, хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигчийг ИНД-12, 21, 26, 39, 43, 47, 61, 63, 66, 67, 91, 92, 93, 95, 115, 119, 129, 133 болон 137-г мөрдөхийг шаардахгүй.

102.19. Гэрчилгээний хугацаа

- (a) Дарга, энэ Дүрмийн дагуу гэрчилгээ олгох, эсхүл сунгахдаа гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусах огноог тогтоох үүрэгтэй.
- (b) Дарга, энэ зүйлийн (a)-д заасан хугацааг, тухайн гэрчилгээ олгосон өдрөөс хойш 5-аас дээш жилийн хугацаагаар тогтоохгүй байж болно.

102.21. Хүнгүй агаарын хөлгийн үйл ажиллагааны нөхцөл

- (a) Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг дагаж мөрдөх үүрэгтэй:
- (1) ИНД-101-ийн шаардлага нь тухайн Үйл ажиллагааны тодорхойлолтод заасан үйл ажиллагаанд нийцэхгүй болох хүртэл үргэлжлүүлэн ИНД-101-ийн шаардлагыг;
 - (2) хүнгүй агаарын хөлгийн Үйл ажиллагааны тодорхойлолтод Даргын тогтоосон тухайн нөхцөлийг;
 - (3) 102.11-д шаардсан тухайн Ерөнхий зааврыг.
- (b) Гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд хийгдэж байгаа үйл ажиллагаанд оролцож буй бусад үйл ажиллагаа эрхлэгч, эсхүл ажилтнууд энэ зүйлийн (a)-ийн шаардлагыг мэдсэн бөгөөд мөрдөж байгааг бататгах үүрэгтэй.

102.23. Ерөнхий зааварт өөрчлөлт оруулах

- (a) Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:

- (1) тухайн Ерөнхий зааварт дараах байдлаар нэмэлт өөрчлөлт хийснийг бататгах:
 - (i) гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны тодорхойлолт хүчинтэй хэвээр байхаар;
 - (ii) 102.11(с)-ийн дагуу тусгасан аливаа ИНД-ийн шаардлага байнга хэрэгжиж байгааг бататгахаар;
- (2) Ерөнхий зааварт нэмэлт өөрчлөлт оруулсны дараа, Даргын хэрэгцээнд зориулж, нэмэлт өөрчлөлт бүрийн хувийг Даргад цаг алдалгүй хүргүүлэх;
- (3) Дарга, нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай гэж үзвэл, Ерөнхий зааварт тухайн нэмэлт өөрчлөлтийг оруулах.

(b) Хэрэв хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь дараах аливаа өөрчлөлтийг хийхээр санал болгож байгаа бол, Даргын зөвшөөрлийг урьдчилан авах шаардлагатай:

- (1) тухайн гэрчилгээний эрхийг хэрэгжүүлэхэд хяналт тавих эрх бүхий, эсхүл хяналт тавих боломжтой аливаа этгээдийг тодорхойлох;
- (2) тухайн гэрчилгээ эзэмшигч хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа явуулах байрлалыг тодорхойлох.

102.25. Гэрчилгээ сунгах

Гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссанаас хойш үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх хүсэлтэй, хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусахаас 90 хоногийн өмнө гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргах үүрэгтэй.

--oOo--